

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/906 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Он тооллын цаглабарын хуучин он улирч, шинэ он гарч буй баярт зориулан шинэ жилийн баярыг дүүргийн хүүхэд багачууд, нийт иргэдийн дунд батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Шинэ жилийн баярын үйл ажиллагааг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Ажлын хэсэг /Ж.Лхагвасүрэн/-т, баярын үйл ажиллагаанд иргэд олон нийтийг өргөнөөр хамруулахыг хороодын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ